



THE BUSINESS COUNCIL of MONGOLIA

Express Tower, 12-th floor
Peace Avenue, PO Box-29
Ulaanbaatar, Mongolia
Tel/Fax: 976-11-317027
Email: info@bcmongolia.org
www.bcmongolia.org

1/23

2011 оны 10 сарын 7

Монгол Улсын их хурлын гишүүд, Засгийн газарт хүргүүлэх нээлттэй захидал

Монгол улсын Засгийн газартай Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан онцгой үйл явдлаас хойш дотоод, гадаадын түншүүд Монгол улсын эрдэс баялгийн асар их нөөцийг хамтран эзэмшихээр нэгдэх болсон билээ. Хэлэлцэж тохирсон гэрээ хэлцэл дээр үндэслэн дэлхий нийтийн хөрөнгийн зах зээл дээр дорвитой хөрөнгийг босгож байгаа нь Монгол хүмүүсийн ажлын байрыг эрс нэмэгдүүлж хөгжин дэвшихэд нь томоохон түлхэц болох юм. Дэд бүтэц, эрүүл мэнд, боловсрол болон бусад үйлчилгээний хүрээг эрс нэмэгдүүлэх амлалтаас гадна энэхүү өсөлт нь Монгол залуусыг урт удаан хугацаанд тогтвортой ажлын байраар хангах үндсэн нөхцөл нь болох билээ.

Оюу Толгойн олон тэрбум ам. долларын Хөрөнгө оруулалтын гэрээний тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхээ тодорхой мэдэгдсэн Засгийн газрын байр сууринд бид талархаж байна.

2010 онд Хөрөнгө оруулалтын гэрээг үзэглэхэд дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчид аль аль нь сайхан мэдээ дуулгасанд баяр хүргэж сайшаан дэмжиж байсан билээ. Үүгээрээ УИХ болон Засгийн газар “бизнес нээлттэй” бодлогоо нотолж уул уурхайн төслүүд амьдралд хэрэгжүүлэхийн тулд хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулах хүсэл эрмэлзлэлтэй байж чаддагаа харуулсан.

Оюу Толгой буюу өөр ямар нэг төслийг дахин хэлэлцэх аливаа оролдлого нь дотоод болон гадаадын аль алиных нь албан ёсны түнш байх нэр хүндээ бий болгох тус улсын хүчин чармайлтыг үгүй хийх юм. Эрсдэл болон шагнал урамшуулалын аль аль нь буй бизнесийг явуулах зөв найдвартай газарт нэр хүндээ бий болгохоор Монгол улс хэдийн хөдлөөд байна. Итгэл найдварын нэр хүндээ хайрлан хамгаалах явдал Монголын ард түмний ашиг сонирхолын нэг гэж бид үзэж байна. Хэдэн арван мянган Монголчуудыг ажлын байраар хангаж буй өөрийн 200 гишүүний нэрийн өмнөөс Монгол улсын Бизнесийн зөвлөл байгуулсан гэрээнүүдийнхээ тогтвортой байдлыг хангахаа дахин

нотлож байгааг сайшаан баяр хүргэж байна. Монгол улсын эрхзүйт төрийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөгжил дэвшилд өөрийн хувь нэмрээ оруулах үүднээс Монгол улсын Бизнесийн зөвлөл бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллах болно.

МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛ,

МБЗ-ийн ТУЗ-ийн Гишүүн байгууллагууд

Бороо Гоулд

Брейктрүү ПиАр

Жаст Групп

КьюЖиЭкс Монгол

Линч & Махони

Лэйтон Ази

Мандал Женерал Даатгал

Монголиан Стар Мелшерс

Монголын Алт Корпораци

Монголын Хөрөнгө Оруулалтын Банк

Моннис Интернэшнл

Ньюком Групп

Оюу Толгой

Петро Матад

Пибоди Энержи

Прайсватерхаус Күүпэрс

Рио Тинто

Сант Марал Сан

Саут Гоби Сэндс

Таван Богд

Хаан Банк

Худалдаа Хөгжлийн Банк

ЭмСиЭс Групп

Эрдэнэ Ресорсез Девелопмент